

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.4.6-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн хойд Азийн хотуудын өмнө тулгарч байгаа асуудлуудыг хэлэлцэж, харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2018 оны 06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулах “Зүүн хойд Азийн хотын дарга нарын форум” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- |         |  |
|---------|--|
| Ахлагч  | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга<br>М.Отгонбаяр  |
| Гишүүд: | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд;<br><br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү;<br><br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр;<br><br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А. Даваажаргал;<br><br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Э.Дагиймаа;<br><br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Эрдэнэжаргал;<br><br>-Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Д.Оюунболор;<br><br>-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн Цагдаагийн газрын дарга Д.Ядамдорж;<br><br>-Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн;<br><br>-Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх; |

-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга  
Л.Эрдэнэчулуун;

-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга  
О.Чинзориг;

-Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга  
Х.Эрдэнэбилэг;

-Замын цагдаагийн албаны Нийслэлийн замын  
хөдөлгөөний хяналтын газрын дарга Б.Эрдэнэбат;

-Зүүн хойд Ази судлалын эксперт С.Бадрал  
/тохиролцсоноор/;

-Азийн сангийн Ногоон хөгжлийн хөтөлбөрийн ахлах  
зохицуулагч Н.Ариунаа /тохиролцсоноор/;

-“Саундс оф Монголиа” ХХК-ийн захирал  
Х.Дамдинсүрэн /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад  
харилцааны хэлтсийн дарга Ш.Сүхбаатар;

-Нийслэлийн Байгаль орчны газрын дарга Э.Баттулга.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг өндөр хэмжээнд  
зохион байгуулж, дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД